

ТӨСӨЛ

Санхүүгийн зохицуулах хорооны ... оны
... сарын ...-ны өдрийн ... дугаар
тогтоолын хавсралт

ХААЛТТАЙ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦААГ БҮРТГЭХ, ХАДГАЛАХ, АРИЛЖИХ, ӨМЧЛӨХ ЭРХ ШИЛЖҮҮЛЭХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэ журмаар Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх)-оос хаалттай хувьцаат компанийн хувьцааг бүртгэх, бүртгэлд өөрчлөлт оруулах, бүртгэлээс хасах, хадгалах, өмчлөх эрхийг шилжүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулна.

1.2. Нээлттэй хувьцаат компани болох зорилгоор арилжаа эрхлэх байгууллагын бүртгэлд бүртгүүлэх хаалттай хувьцаат компанийн хувьцааг бүртгэх, арилжихтай холбоотой харилцааг зохицуулах журмыг арилжаа эрхлэх байгууллага баталж, Хороогоор батламжлуулна.

ХОЁР. ҮНЭТ ЦААСНЫ ТӨВЛӨРСӨН ХАДГАЛАМЖИЙН БАЙГУУЛЛАГЫН БҮРТГЭЛД ХУВЬЦААГ БҮРТГЭХ

2.1. Хувьцаагаа бүртгүүлэхээр хүсэлт гаргагч хаалттай хувьцаат компани нь дараах баримт бичгийг хавсаргаж, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагад 2 хувь хүргүүлнэ. Үүнд:

2.1.1. хувьцаа бүртгүүлэх хүсэлт /Хавсралт-1/;

2.1.2. компанийн хэлбэрийг хаалттай хувьцаат компани болгон шийдвэрлэх тухай эрх бүхий байгууллагын шийдвэр;

2.1.3. улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;

2.1.4. компанийн дүрмийн хуулбар;

2.1.5. компанийн хувьцаа эзэмшигчдийн хувьцааны талаарх дэлгэрэнгүй мэдээлэл;

2.1.6. хүсэлт гаргах үед зээл, баталгаа, батлан даалтын гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн болон шүүхийн шийдвэрээр гүйцэтгэх өр төлбөртэй эсэх лавлагаа;

2.1.7. төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн болон компанийн засаглалыг хэрхэн хэрэгжүүлэн ажилладаг талаарх мэдээлэл.

2.2. Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага нь энэ журмын 2.1-д заасан баримт бичгийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 10 өдөрт багтаан хянаж, бүртгэх эсэхийг шийдвэрлэнэ.

2.3. Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага нь хаалттай хувьцаат компанийн анх удаа болон нэмж гаргаж байгаа хувьцааг бүртгэх хүсэлтийг хүлээн авч, шаардлага хангасан гэж үзвэл эх баримт бичгийн нэг хувийг Хороонд ирүүлнэ.

ТӨСӨЛ

2.4. Хорооны дарга энэ журмын 2.3-т заасан баримт бичигт үндэслэн зөвхөн татгалзсан тохиолдолд хариу хүргүүлэх бөгөөд тус албан бичигтээ татгалзах болсон үндэслэлээ тусгаж үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагад баримт бичгийг хүлээн авснаас хойш ажлын 5 хоногийн дотор хүргүүлнэ.

2.5. Хаалттай хувьцаат компанийн хувьцааг бүртгэх тухай үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагын шийдвэрийн салшгүй хэсэг нь энэхүү журмын хавсралт 2-т заасан мэдээлэл байна.

ГУРАВ. ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖАА ЭРХЛЭХ БАЙГУУЛЛАГЫН БҮРТГЭЛД ХУВЬЦААГ БҮРТГЭХ, АРИЛЖИХ

3.1. Нээлттэй хувьцаат компани болох зорилгоор арилжаа эрхлэх байгууллагын бүртгэлд бүртгүүлэх хүсэлт гаргагч хаалттай хувьцаат компани нь үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагын бүртгэлд хувьцаагаа хадгалуулсан байна.

3.2. Нээлттэй хувьцаат компани болох зорилгоор арилжаа эрхлэх байгууллагын бүртгэлд бүртгүүлэх хүсэлт гаргагч хаалттай хувьцаат компани нь дараах баримт бичгийг хавсаргаж, үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад хүргүүлнэ. Үүнд:

3.2.1. хаалттай хувьцаат компанийн хувьцааг бүртгэх тухай үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагын шийдвэрийн хуулбар;

3.2.2. хувьцаа бүртгүүлэх хүсэлт;

3.2.3. хаалттай хувьцаат компанийг арилжаа эрхлэх байгууллагад бүртгүүлэх тухай эрх бүхий байгууллагын шийдвэр;

3.2.4. компанийн танилцуулга;

3.2.5. хаалттай хүрээнд гаргах үнэт цаасны танилцуулга;

3.2.6. шаардлагатай бусад.

3.3. Нээлттэй хувьцаат компани болох зорилгоор арилжаа эрхлэх байгууллагын бүртгэлд бүртгүүлэх хаалттай хувьцаат компанийн хувьцаа бүртгүүлэх хүсэлт болон үнэт цаасны танилцуулгад заасан хувьцааны нэр, төрөл, тоо, хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл, хувь эзэмшлийн хэмжээ, нэрлэсэн үнэ, хувьцааны нийт үнийн дүн нь үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагын бүртгэлийн мэдээлэлтэй ижил байна.

3.4. Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага нь нээлттэй хувьцаат компани болох зорилгоор хаалттай хувьцаат компаниар бүртгүүлэх хүсэлт гаргаж буй хаалттай хувьцаат компанийн хүсэлтийг хүлээн авч, шаардлага хангасан гэж үзвэл Хороо болон үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагад мэдэгдэнэ.

3.5. Хорооны дарга, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага энэ журмын 3.4-т заасан мэдэгдэлд үндэслэн зөвхөн татгалзсан тохиолдолд хариу хүргүүлэх бөгөөд тус албан бичигтээ татгалзах болсон үндэслэлээ тусгаж үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад мэдэгдэл хүлээн авснаас хойш ажлын 5 хоногийн дотор хүргүүлнэ.

3.6. Хаалттай хувьцаат компанийн нээлттэй компани болох зорилгоор гаргасан хувьцааг мэргэжлийн хөрөнгө оруулагчид санал болгож, тэдгээрийн хооронд арилжаална.

**ДӨРӨВ. ҮНЭТ ЦААСНЫ ТӨВЛӨРСӨН ХАДГАЛАМЖИЙН
БАЙГУУЛЛАГЫН БҮРТГЭЛД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ, ХАСАХ**

4.1. Дараах тохиолдолд хаалттай хувьцаат компанийн хувьцааны бүртгэлд өөрчлөлт оруулна. Үүнд:

4.1.1. хаалттай хувьцаат компани нь нэмж хувьцаа гаргах эсхүл хувьцааг хэсэгчлэн хасах тухай шийдвэр гаргасан;

4.1.2. хаалттай хувьцаат компани нь нэгдэх, нийлэх, хуваах, тусгаарлах болон өөрчлөх замаар өөрчлөн байгуулагдсан;

4.1.3. хаалттай хувьцаат компани нь хувьцааг хуваах, нэгтгэх, нэрлэсэн үнийг өөрчлөх тухай шийдвэр гаргасан;

4.1.4. бүртгэлтэй хувьцааны нэр өөрчлөгдсөн;

4.1.5. хууль, холбогдох журамд заасан бусад үндэслэл.

4.2. Дараах тохиолдолд хаалттай хувьцаат компанийн хувьцааг бүртгэлээс хасна. Үүнд:

4.2.1. үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагаас хаалттай хувьцаат компанийн хувьцааг хасах тухай шийдвэр гарсан;

4.2.2. компанийн хэлбэрийг өөрчлөн байгуулж хязгаарлагдмал хариуцлагатай компани болох тухай шийдвэр гарсан;

4.2.3. Шүүх, прокурор, төрийн эрх бүхий байгууллагаас компанийн эрх бүхий албан тушаалтан, түүний хараат, охин компанийг хариуцагчаар татаж, захиргааны болон эрүүгийн хэрэг үүсгэсэн, шүүхээс дампуурлын тухай хууль тогтоомжийн дагуу эрх хүлээн авагч томилогдсон.

4.2.4. хууль, холбогдох журамд заасан бусад үндэслэл.

4.3. Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагаас хаалттай хувьцаат компанийн хувьцааг хасах тухай шийдвэр гарснаас хойш ажлын 3 хоногийн дотор Хороо болон үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагад хувийг хүргүүлнэ.

ТАВ. ХУВЬЦААГ ХАДГАЛАХ

5.1. Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага нь хадгалуулж буй хувьцааг төрөл тус бүрээр нэгдсэн дугаар (код) өгч бүртгэнэ.

5.2. Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага нь хаалттай хувьцаат компанитай хувьцааны хадгаламжийн болон түүнтэй холбогдолтой төлбөр гүйцэтгэх гэрээ байгуулна.

5.3. Энэхүү журмын 5.2-т заасан хувьцааны хадгаламжийн гэрээнд хадгаламжийн хэлбэр, хадгалуулах хувьцааны төрөл, тоо ширхэг, хадгаламжийн үйлчилгээний хөлсний

хэмжээ, хөлс төлөх хугацаа, хадгаламжийн гэрээг цуцлах нөхцөл, гэрээгээр хүлээсэн үүргийг гүйцэтгээгүйгээс үүсэх хариуцлагыг тодорхой тусгасан байна.

**ЗУРГАА. ҮНЭТ ЦААСНЫ ТӨВЛӨРСӨН ХАДГАЛАМЖИЙН
БАЙГУУЛЛАГЫН ХУВЬЦААНЫ БҮРТГЭЛД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ,
ТУСГААРЛАХ, БҮРТГЭЛЭЭС ХАСАХ**

6.1. Дараах тохиолдолд хаалттай хувьцаат компанийн хувьцааны бүртгэлд өөрчлөлт оруулна. Үүнд:

6.1.1. хаалттай хувьцаат компани нь нэмж хувьцаа гаргах эсхүл хувьцааг хэсэгчлэн хасах тухай шийдвэр гаргасан;

6.1.2. хаалттай хувьцаат компани нь нэгдэх, нийлэх, хуваах, тусгаарлах болон өөрчлөх замаар өөрчлөн байгуулагдсан;

6.1.3. хаалттай хувьцаат компани нь хувьцааг хуваах, нэгтгэх, нэрлэсэн үнийг өөрчлөх тухай шийдвэр гаргасан;

6.1.4. бүртгэлтэй хувьцааны нэр өөрчлөгдсөн;

6.1.5. хууль, холбогдох журамд заасан бусад үндэслэл.

6.2. Хаалттай хувьцаат компани нь хувьцааны бүртгэлд өөрчлөлт оруулах тухай хүсэлтийг энэ журмын хавсралт 3-т заасан маягт болон холбогдох баримт бичгийн хамт үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагад гаргана. Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага тус холбогдох баримт бичигтэй холбоотойгоор нэмэлт тодруулга, мэдээлэл шаардлагатай баримт бичиг ирүүлэхийг хаалттай хувьцаат компаниас шаардаж болно.

6.3. Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага нь энэ журмын 6.2-т заасан баримт бичгийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 5 өдрийн дотор хянан шийдвэрлэнэ.

6.4. Дараах тохиолдолд хаалттай хувьцаат компанийн хувьцааг үнэт цаасны төвлөрсөн хадгаламжаас хасна. Үүнд:

6.4.1. компанийн хэлбэрийг өөрчлөх тухай шийдвэр гаргасан;

6.4.2. Шүүх, прокурор, төрийн эрх бүхий байгууллагаас компанийн эрх бүхий албан тушаалтан, түүний хараат, охин компанийг хариуцагчаар татаж, захиргааны болон эрүүгийн хэрэг үүсгэсэн, шүүхээс дампуурлын тухай хууль тогтоомжийн дагуу эрх хүлээн авагч томилогдсон.

6.5. Хаалттай хувьцаат компани нь хувьцаагаа хадгаламжийн байгууллагын бүртгэлээс хасуулах асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэнэ.

6.6. Хаалттай хувьцаат компани нь хувьцаагаа бүртгэлээс хасуулах хүсэлтийг холбогдох баримт бичгийн хамт үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагад гаргана.

ТӨСӨЛ

6.7. Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага нь хувьцааг хадгаламжаас хасахтай холбоотой шаардлагатай гэж үзсэн нэмэлт баримт бичгийг ирүүлэхийг хаалттай хувьцаат компаниас шаардаж болно.

6.8. Хаалттай хувьцаат компани нь хувьцаа эзэмшигчийн өмнө хуулиар хүлээсэн аливаа үүргээ биелүүлээгүй нь түүний хувьцааг хадгаламжийн бүртгэлээс хасахгүй байх үндэслэл болно.

6.9. Хадгалагч нь дараах тохиолдолд хувьцааг тусгаарлаж болно. Үүнд:

6.9.1. Хорооны улсын байцаагчийн албан шаардлага;

6.9.2. хууль хяналтын байгууллагын мэдэгдэл, шийдвэр;

6.9.3. хувьцаа эзэмшигчийн өөрийн хүсэлт.

6.10. Хувьцааг тусгаарлалтаас чөлөөлөхдөө тусгаарлуулсан этгээд эсхүл дээд шатны албан тушаалтны шийдвэр, хувьцаа эзэмшигчийн хүсэлтийг үндэслэнэ.

6.11. Хувьцаа эзэмшигчийн хүсэлтээр тусгаарлагдсан хувьцааг тусгаарлах тухай хууль хяналтын байгууллагаас аливаа хүчин төгөлдөр шийдвэр ирүүлсэн тохиолдолд харилцагчийн хүсэлтийг үл харгалзан хууль хяналтын байгууллагын шийдвэрийг хэрэгжүүлнэ.

ДОЛОО. ХУВЬЦААНЫ ӨМЧЛӨХ ЭРХ БУСДАД ШИЛЖСЭНИЙГ БҮРТГЭХ, ТҮҮНД ТАВИГДАХ ШААРДЛАГА

7.1. Хувьцааны өмчлөх эрх шилжүүлэн авч байгаа этгээд өмчлөх эрх шилжүүлэн бүртгүүлэх хүсэлтийг холбогдох баримт бичгийн хамт ажлын 5 хоногийн дотор үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагад гаргана.

7.2. Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага нь хувьцаа худалдах, худалдан авах гэрээ, өв залгамжлах эрхийн гэрчилгээ, бэлэглэлийн гэрээ, хууль хяналтын болон эрх бүхий байгууллагын тогтоол шийдвэрийг үндэслэн өмчлөх эрхийг шилжүүлж бүртгэл хөтөлнө.

7.3. Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага нь худалдах, худалдан авах гэрээний дагуу дараах баримтыг үндэслэн хувьцааны өмчлөх эрх шилжсэнийг бүртгэнэ. Үүнд:

7.3.1. худалдах, худалдан авах гэрээний эх хувь;

7.3.2. худалдах, худалдан авах гэрээний дагуу хийгдсэн төлбөр төлөгдсөн баримтын хуулбар;

7.3.3. талуудын цахим үнэмлэхийн хуулбар.

7.4. Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага нь хувьцааны өмчлөх эрхийн бүртгэлд өв залгамжлалаар өөрчлөлт оруулах тохиолдолд дараах баримт бичгийг үндэслэн хувьцааны өмчлөх эрх шилжсэнийг бүртгэнэ. Үүнд:

7.4.1. өвлөгчийн өв хүлээн авахыг хүссэн өргөдөл;

7.4.2. өв залгамжлах эрхийн гэрчилгээ;

7.4.3. өвлөгчийн цахим үнэмлэхийн хуулбар;

7.4.4. өвлүүлэгчийн гэрээслэл.

7.5. Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага нь өв нээгдсэн тухай мэдэгдэл ирсэн тохиолдолд өвлөгчид шилжих хүртэл хугацаагаар өвлүүлэгчийн данснаас гүйлгээ хийхийг хориглоно.

7.6. Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага нь хууль хяналтын болон эрх бүхий байгууллагын хүчин төгөлдөр тогтоол, шийдвэр, эсхүл үл маргах журмаар өмчлөх эрх шилжсэнийг бүртгэх тохиолдолд дараах баримтыг үндэслэнэ. Үүнд:

7.6.1. хувьцаа эзэмшигчийн хүсэлт, гэрээ дүгнэсэн акт;

7.6.2. шүүхийн шийдвэр, гүйцэтгэх хуудас.

7.7. Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага нь энэхүү журамд заасан өмчлөх эрхийн гүйлгээтэй холбоотой баримтын бүрдэл, шаардлага хангасан тохиолдолд өмчлөх эрх шилжсэнийг бүртгэх бөгөөд шаардлага хангаагүй тохиолдолд өмчлөх эрх шилжүүлэн бүртгэл хийхээс татгалзах эрхтэй.

7.8. Гүйлгээний баримт шаардлага хангахгүй тохиолдолд баримтын бүртгэл хөтөлж буцаан хүлээлгэн өгнө.

~oOo~

ТӨСӨЛ

*“Хаалттай хувьцаат компанийн хувьцааг бүртгэх, хадгалах,
арилжих, өмчлөх эрх шилжүүлэх журам”-ын
Хавсралт - 1*

**ҮНЭТ ЦААСНЫ ТӨВЛӨРСӨН ХАДГАЛАМЖИЙН БАЙГУУЛЛАГАД
ХУВЬЦАА БҮРТГҮҮЛЭХ ӨРГӨДӨЛ**

Огноо :/...../.....

Хаана: “.....” ХХК-д

.....
.....

(хаяг, утас, факс, шуудангийн ба цахим шуудангийн хаяг)

Хэнээс:

/хуулийн этгээдийн нэр/

.....
.....

(хаяг, утас, факс, шуудангийн ба цахим шуудангийн хаяг)

Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын 20.... оны дугаар сарын-ны өдрийн
тоот тогтоолыг үндэслэн үнэт цаасаа бүртгүүлэн хадгалуулах хүсэлт гаргаж байна.

ӨРГӨДӨЛ ГАРГАГЧ:

.....

/албан тушаал /

/тамга тэмдэг/

/.....//...../

/гарын үсэг/

/овог, нэр/

ТӨСӨЛ

*“Хаалттай хувьцаат компанийн хувьцааг бүртгэх, хадгалах,
арилжих, өмчлөх эрх шилжүүлэх журам”-ын
Хавсралт - 2*

ХАДГАЛАМЖИД БҮРТГЭХ ХУВЬЦААНЫ МЭДЭЭЛЭЛ

Үзүүлэлт		Хувьцааны бүртгэл
Хувьцааны код:		
Хувьцааны нэр:		
Хувьцааны төрөл:		
Нийт хувьцааны тоо : /ширхэг/		
Хувьцаа эзэмшигч:	Овог нэр	
	Тоо /ширхэг/	
	Хувь /%/	
Хувьцаа эзэмшигч:	Овог нэр	
	Тоо /ширхэг/	
	Хувь /%/	
Хувьцаа эзэмшигч:	Овог нэр	
	Тоо /ширхэг/	
	Хувь /%/	
Нэрлэсэн үнэ: /төгрөг/		
Хувьцааны нийт үнийн дүн: /төгрөг/		

ТӨСӨЛ

*“Хаалттай хувьцаат компанийн хувьцааг бүртгэх, хадгалах,
арилжих, өмчлөх эрх шилжүүлэх журам”-ын
Хавсралт - 3*

**ХУВЬЦААНЫ ХАДГАЛАМЖИЙН БҮРТГЭЛД
ОРОХ ӨӨРЧЛӨЛТИЙН МЭДЭЭЛЭЛ**

..... хаалттай хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын 20.... оны
.... дугаар сарын-ны өдрийн дугаар тогтоолыг үндэслэн хувьцааны хадгаламжийн
бүртгэлд дараах өөрчлөлтийг оруулав.

Үзүүлэлт	Хувьцааны бүртгэл
Хувьцааны код:	
Хувьцааны нэр:	
Хувьцааны төрөл:	
Нийт хувьцааны тоо:	
Нэгжийн нэрлэсэн үнэ: /төгрөг/	
Бүртгэлд орсон өөрчлөлт	
Нэмэгдсэн /хасагдсан/ хувьцааны тоо:	
Нэг бүрийн үнэ:	
Дүрмийн санг нэмэгдүүлэх /хасагдуулах/ дүн:	
Хувьцааг хуваах, нэгтгэх замаар өөрчилсөн тухай мэдээлэл:	
Нэрлэсэн үнэ өөрчилсөн тухай мэдээлэл:	
Хувьцааны нэр өөрчилсөн тухай мэдээлэл:	
Нийт гаргасан хувьцааны тоо : /ширхэг/	
Хувьцааны нийт үнийн дүн: /төгрөг/	